

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Да лам	Дугаар	L284
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Мөрөн сум
Төрсөн газар	Мөрөн сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Мөрөнгийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨМХ 040
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Мөрөнгийн хүрээ

Мөнхбат: За 1990-ээд оноос ардчилсан нийгмийн байгуулалд монгол орон шилжиж хүний эрх эрх чөлөө шашин шүтэх энэ эрх чөлөөг дээдэлсэн ийм нийгмийн хөгжлийн замд монголчууд бид эргэлт буцалтгүй орсон.Түүнээс хойш үндсэндээ нэг арван долоон жилийн нүүр үзэж байна. Тэгэхээр Гандандаржаалин хийд маань тэр цагт баригдсан одоо хүнээр бол эрийн цээнд хүрсэн ийм үе юм.Ингэхээр одоо өнөөдрийн энэ өндөрлөгөөс тэртээ арван хэдэн жилийн өмнөх үе буюу хийд одоо анх байгуулагдаж байсан цаг үеийг эргэн дурсвал одоо танд ямар сэтгэгдэл төрж байна вэ?

Даа лам: За шашин дахин сэргэсэн буюу одоо ерээд оноос хойш арван долоон жил болж байна. Манай Гандандаржаалин хийд маань ерэн оны гурван сарын гучин нэгний өдөр одоо анх энэ үрд талын энэ саад байгаа модтой газар анх одоо арав гаран лам манай одоо хөгшин лам нар сууж шавыг нь тавьж байсан юм

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байна лээ.Одоо манай архивт бичлэг нь байдаг юм, яг тэр үеийнх нь.За тэгээд тэрнээс хойш тасралтгүй ном хурлаа хураад ерэн долоон онд хоёр дахь дуган нь нээгдсэн юм аа.Хоролбат лам, шашны дээд сургуулийн Хоролбат ламын санаачилгаар одоо Ахай бэйсийн хошууны гол шүтээн болсон энэ сахиусныхаа дуганыг анх одоо нээж хурал номын үйл ажиллагаанд оруулсан.За тэрнээс хойш одоо энэ 2004 онд энэ сургалтын байр гэх том байрыг бариад манайх бас хөрөнгө мөнгөний гачигдал, за дээр нь одоо бас олон хийдүүд ч гэх юм уу даа, гүрмийн газар гарч байна. Тийм учраас одоо бас сүсэгтэн олны наашаа хандах хандлага нь бас ингэж тарч бутраснаас болоод одоо хөрөнгө санхүүгийн эх үүсвэр одоо бид нарын хурлын газар дандаа л жандагаар явдаг учраас тэр маань бас жаахан тэгээд ашиглалтанд орох боломжгүй болсон юм аа.За тэгээд одоогийн байдлаар бол тэгээд гучаад ламтай байна.Одоо нэг хамбатай, даа ламтай хоёр унздатай гэсгүйтэй за одоо тэгээд хийд орны байдлыг хангасан одоо ийм л байна даа.

Мөнхбат: Тэгэхээр Гандандаржаалин хийдийн гол шүтээн сахиус одоо ямар бүрхан байдаг вэ, за мөн энэ хийд маань одоо өдөр тутмын уншлагатай, байнгын үйл ажиллагаатай, ямар ямар хурал номуудыг одоо голлон хурж сүсэгтэн олондоо үйлчилж байна вэ?

Даа лам: За өдөр тутмын хурлаа хурна, өдөр тутам цогчин уншлагаа уншина,цогчин дугандаа болохоор.За сахиусныхаа дуганд болохоор сахиусаа тахина. Манай гол шүтээн юу вэ гэхээр Хар морьт сахиус гэж байдаг.Тан чойжил, бүрли чойжил гэж ярьдаг.Ахай бэйсийн хошууны гол шүтээн байдаг юм аа.Энийгээ бид нар нандигнан шүтэж явдаг юм аа. За хоёр дахь шүтээн нь бол Жамсран сахиус гэж байдаг.Тэгээд энэ хоёрыгоо шүтэж явдаг. За цогчин уншлаганд маань нэг жар гаруй ном багтдаг.Аа сахиусны уншлаганд болохоор тэр Хар морьт сахиусныхаа цолжидыг уншаад тэгэд бас айлтгалын хангалуудыг ингэж уншдаг.Тэгээд бас өдөр болгон хүмүүсийн айлтгаж орж ирсэн номуудыг цогчин уншлагандаа бас оруулж уншдаг.

Мөнхбат: За тэгэхээр Гандандаржаалин хийд манай орны бусад аймгуудын төвд баригдсан хийд хурал номын газруудаас ялгарах өвөрмөц онцлогтой байна.Зүгээр бидний ажигласнаар, за юуны өмнө материаллаг баазын хувьд нэлээн өндөр хэмжээнд хүрсэн юм уу, за энд баригдсан сүм дуганууд зүгээр хэлбэр төдий биш, үнэхээр эртний дорно дахины буддын сүм хийдийн хэв загвар агуулга үзэл санааг одоо нэлээн баримталсан юм уу гэмээр санагдаж байна. За нөгөө талаар бас энэ цаг үе дор хамгийн олзуурхууштай нь үнэхээр одоо сүм хийдээ гэсэн ийм лам нарын тоо одоо чанартай гэдэг юм уу, тийм ээ жинхэнэ сахил хүртсэн ийм одоо санваартнуудын тоо одоо гуч гаруй ламтай гэхээр бусад аймгуудтай харьцуулахад нэлээд өндөр үзүүлэлт юм болов уу бодож байна. Тэгэхээр одоо энэ зүүн талд, танай энэ элбэг хашаан дотор зүүн талд нэгэн шинэ дуган баригдаж байна. Тэгэхээр энэ дуган одоо ямар учиртай сул дуган уу, санхүүжилт яаж шийдэгдэж байна. Хэдийгээр ашиглалтанд орох уу, энэ дуган баригдсанаар одоо сүсэгтэн олонд ямар ямар үйлчилгээ үзүүлэх боломжийг агуулах вэ?

Даа лам: За энүүний одоо хөрөнгийн эх үүсвэр юу вэ гэхээр БСШУЯ-аас соёл урлагийн сангаас бас тодорхой хэмжээгээр гаргаж байгаа юм байна лээ. Тэгээд Хөвсгөл хүрээ сан гэсэн ийм хоёр газар нийлж хөрөнгийг нь шийдэж гаргаж байгаа юм. Тэгээд бас бусад одоо нийт жаран дөрвөн саяар босно гэж байгаа юм, энэ дуган.Ер нь яг гадных нь юу ш дээ, объект нь дотрох бүрхан шүтээн нь чимэг зүүлт нь ерөөсөө тэндээ орж амжихгүй юм

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байна лээ. За энэ маань долоон сарын хорин гэхэд Хотгойдын их хурд болно гэж Хөвсгөл аймагт яригдаж байгаа. Тэгээд бас яг тэр үеэр нээлтээ хийх бодлоготой байгаа. Тэгээд бас одоо энэ дугандаа ямар ямар хурал ухрах вэ гэхээр арван хангалын дуган гэж нээж байгаа юм, яг гол зорилго нь арван хангалын дуган, хангалын дуган гэж. Тэгээд энэ дугандаа бас өдөр тутмаас, лам нараасаа бол тэнд нь суулгаад, дөрөв таван лам суулгаад. Ингээд өдөр болгон хангал догшидоо тахиад зан үйлээ үйлдэнэ дээ.

Мөнхбат: За сүм хийдийнхээ хойшдын үйл ажиллагааг хэвийн авч явах үүднээс одоо хойшид энд хурж хуралд сууж байх шашны өндөр боловсролтой лам хуварга бэлтгэх, ер нь хойч үеэ бэлтгэх талаар хийд одоо ямар бодлого баримталж байна, тэгээд одоо танай хийдээс одоо гадаад дотоодын бурхан шашны их сургуульд суралцаж байсан хүүхэд хэр байдаг юм, одоо байна уу?

Да лам: За манайх боловсролынхоо лам нарын мэдлэгийн тал дээр нэлээн анхаардаг гэж үздэг юм аа. Ерээд оноос эхлээд ер нь лам нарыгаа нэг хоёроор нь явуулаад шашны дуганд сургасан. Ерэн дөрвөн оноос шашны дээд сургуульд лам нарыгаа бас ингэж явуулж сургаж ирсэн юм аа. Одоогийн байдлаар бол сурж байгаа хүүхэд гэвэл нэг долоон лам байна, шашны сургуульд сурж байга. Нацагдорж гуайн одоо олон жил анагаахад, мамба дацанд одоо нэг хүүхэд сураад энэ жил төгсөж ирсэн. Одоо эндээ ажиллана. Анагаахын чиглэлээр ажилласан. За шашны одоо яг суралцаж байгаа хүмүүс гэвэл дөрвөн лам байна. Хоёр нь энэ жил одоо буддын гүн ухааны ангийг төгсөж гарч ирж байгаа ийм улсууд байна.

Мөнхбат: За энэ өнгөрсөн энэ хугацаанд одоо Энэтхэг, Төвдөөс гэдэг юм уу, манай бурхан шашны төвөөс ямар ямар эрдэмтэй чадалтай лам нар ихэс дээдэс мяндагтнууд танай одоо хийдэд морилж ирсэн байх юм, энэ түүхээсээ сонирхуулна уу?

Даа лам: За ерэн гурван оны одоо зун манай монгол дахь элчин сайд байсан энэ одоо Бахула ринбүүчий багш маань энд морилж байсан юм аа. За тэгээд ерэн гурван оны бас намар нь одоо хотод манай эндхийн бас дархан үнзад, төв хүрээний дархан үнзад хийж байсан хүн бас энд морилж байсан юм. Аа ерэн долоон онд Чойжамц хамба бас энд морилж ирж байсан. За 2002 онд одоо Гунгаачойлин дацангийн шунлайв лам Гүндсамбуу гэдэг хүн одоо энд ирж одоо номынхоо абшигийг бидэнд тавьж олон лам нарт одоо гэлэн сахил хүртээж ингэж байсан. Тэгээд 2004 оны зун одоо Амгалан хамба, дэд хамба гуай ингэж морилж байсан, ийм юм байгаа.

Мөнхбат: За таньд баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл, Гандандаржаалин хийдийн түүх, Монголын буддын сүм хийдийн судалгааны багт одоо үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Ингээд бурхан шашны үйл хэргийг түгээн дэлгэрүүлэх, сүсэгтэн олондоо үйлчлэх таны зам мөр өлзийтэй байх болтугай гэж танд хүсье. Танд баярлалаа.

Даа лам: За за.